



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 524

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 231,910,129.18 (хоёр зуун гучин нэгэн сая есөн зуун арван мянга нэг зуун хорин есөн төгрөг арван найман мөнгө) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Х.Пүрэвжаргал)-д дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

1.1.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

1.2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, төрийн өөрийн өмчит бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авах;

1.3.Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 50 дугаар тогтоолыг мөрдөж, түрээслүүлэгч болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай гурвалсан гэрээ байгуулах;

1.4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг мөрдөж ажиллах;

1.5.“Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын балансд бүртгэлгүй, BMW маркийн 4797 УНИ улсын дугаартай тээврийн хэрэгслийн эзэмшигчийг тогтоож, төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах;

1.6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох дүрэм журмыг мөрдөж ажиллах;

1.7.Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.2 дахь заалтыг мөрдөж ажиллах.

2.Энэхүү хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг давтан гаргасан, хяналт тавих чиг үүргээ биелүүлээгүй албан тушаалтан нарт хариуцлага тооцох.

132005308  
27-r huraldaan.docx

3.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.“Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтэд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т тус тус даалгасугай.


4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн  
10 дугаар тогтоолын хавсралт

“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт  
хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал  
түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /төг./	Авч хэрэгжүүлэх арга хэмжэ
1	Шагнал, урамшуулал, бэлэг дурсгалтай холбоотой үргүй зардал зардал	10,043,496.00	Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх
2	Төрийн өмчийн эд хөрөнгийг данс хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн бүртгэсэн	26,937,272.73	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг мөрдөх
3	Зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө олж авсан	49,724,400.45	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт “Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөрөнгийг ...шинээр авах шийдвэр гаргах нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхэд хамаарна” гэсэн заалтыг мөрдөж, батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд туссан хөрөнгийг бэлтгэж байх
4	Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт	145,204,960.00	Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах
<b>НИЙТ ДҮН</b>		<b>231,910,129.18</b>	<b>(хоёр зуун гучин нэгэн сая есөн зуун арван мянга нэг зуун хорин есөн төгрөг арван найман мөнгө)</b>